



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№116 /330/

2022.06.29

Цаг үе, үйл явдал

## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД БАЯР НААДМЫН БЭЛТГЭЛТЭЙ ТАНИЛЦЛАА



Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өчигдөр Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажилтай танилцлаа.

Батлан хамгаалахын сайдыг Богдхан уулын зүүн энгэр Шажин хурааны аманд хүрэлцэн очиход Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч хурандаа М.Болдбаатар угтан авч, бэлтгэл сургуулилтын талаар мэдээлэл өглөө.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр торгон цэргүүдийн Үндэсний их баяр наадмаар Есөн хөлт цагаан тугийг цэнгүүлэх ёслолын бэлтгэл ажилтай танилцсаны дараагаар "Та бүхэн түүхэн их ойн баяр наадмын бэлтгэлийг сайн базааж байна. Бүх талын бэлтгэл, сургуулилт сайн байгаагийн зэрэгцээ адууны өнгө зүс, тарга тэвээрэг сайхан байгааг харлаа. Наадмын хамгийн оргил, үзэгч олны сэтгэлийг хөдөлгөж огшоосон, гадна дотнын зочид төлөөлөгчдийг гайхшируулдаг үйл явдал бол Есөн хөлт цагаан

тугийг залах энэ үе. Төрийн наадмын гол утга учир нь энэ. Үүнээс илүү дээд төрийн ёслолын арга хэмжээ гэж үгүй. Жилдээ ганц удаа тохиодог энэхүү төрийн ёслолын ажиллагааг үзэх гэж олон хүн хүсэж, хүлээдэг. Энэ хүндтэй үүргийг та бүхэн гүйцэтгэнэ. Үлдсэн хугацаанд бэлтгэл сургуулилтаа улам жигдрүүлээрэй" хэмээн бие бүрэлдэхүүнд амжилт хүсэж, зарим үүрэг чиглэлийг өглөө.

Үргэлжлүүлэн "Найман шарга" амралтын газар хүрэлцэн очиж БХЯ-ны харьяа Алдар спорт хороо, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас баяр наадамд оролцох бөхчүүд, сурчид, шагайн харваачдын бэлтгэлтэй танилцсан юм. Мөн үндэсний бөхийн сорилго барилдаан, сурчид, шагайн харваачдын тэмцээнийг үзэж сонирхлоо.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд "Тулгар төрийн 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 816,

баяраа өргөн дэлгэр тэмдэглэнэ. Тэр ч хэрээрээ түмэн олны хүлээлт өндөр байна. Хэдхэн хоногийн дараа болох Үндэсний их баяр наадамдаа түмэн олноо баясгаж, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийхээ нэрийг өндөрт өргөж сайхан амжилт гаргана гэдэгт итгэлтэй байна" гэсэн юм.

Хамгийн сүүлд буюу Ардын хувьсгалын 99 жилийн ойн баяр наадмын хүчит бөхийн барилдааны шөвгийн 16 бөхийн 10 нь "Алдар" спорт хорооны тамирчид байсан нь урьд өмнө гарч байгаагүй түүхэн амжилт аж.

Батлан хамгаалахын сайдыг дагалдаж БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал



Ардын хувьсгалын 100, 101 жилийн баяр наадмыг зохион байгуулах ажил ид өрнөж байна. Хоёр жил дараалан "Ковид-19"-ийн цар тахлын улмаас Үндэсний их баяр наадмыг тэмдэглэлгүй өнжсөн. Өнжиж байсан тохиолдол тун цөөн. Энэ жил тэгш ойн

Д.Ганзориг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү нар ажиллав.

## ОРОЛЦООГ ОНЦОЛЪЁ



Батлан хамгаалах яам, Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Соёлын яам зэрэг дөрвөн яамны хамтарсан оролцоо төсөл 2 дах жилдээ амжилттай үргэлжилж байна.

Залуучуудад эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгож, ажилтай, орлоготой болгох зорилготой "ОРОЛЦОО" төслийн энэ жилийн 2 дугаар ээлжийн 300 гаруй залуус Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн сургалтын полигонд гарчээ.

Тэд сургалтаар ажил, амьдралынхаа гарааг зөв эхлүүлэх, зорилгоо тодорхойлох, өөрийгөө илэрхийлэх, хөдөлмөр эрхлэх чадвар, чиг баримжаа олж авахаас

гадна эх оронч үзэл санаа, эрүүл зөв амьдралын хэв маяг, төлөвшил, гэр бүлийн утга учир, хамтын хүсэл мөрөөдөл, түүнд хүрэх арга замын талаар 14 хонгийн хугацаатай суралцах юм. Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн сургалтын төвд байрлаж буй 2 дугаар ээлжийн оролцогчид ирээд 4 хонож байгаа бөгөөд тэдний сургалтын үйл явцтай танилцахаар ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрыг дарга бригадын генерал Г.Болор өчигдөр тус полигонд очив. Түүнийг дагалдан Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн захирагч А.Бүрнээбаатар, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын мэргэжилтэн дэд хурандаа Н.Батсайхан нар байлцлаа.

Ажлын хэсэгт сургалтын төвийн дарга дэд хурандаа

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 16


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	🌧️ 25

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.146.00	3.152.0
EUR 🇪🇺	3.3220.0	3.340.0
CNY 🇨🇳	471.50	473.00
RUB 🇷🇺	53.50	53.80
JPY 🇯🇵	23.20	23.45
KRW 🇰🇷	2.43	2.46

### ЗУРХАЙ



2022.06.29 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 30

**ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР**

Үс засуулбал:

Эрлэг лугаа учирна  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
04.56-20.55

Барилдлага:

Рашаан

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Мунхрахуй

Суудал: Шороо

Энэ өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, лус тахих, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Цөөрөм байгуулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 550,817,225

Эдгэрсэн

Нийт: 526,382,453

Нас барсан

Нийт: 6,353,989



Цахим шууданд

# ОРОЛЦООГ ОНЦОЛЪЁ



Г.Дунжингарав сургалтын төвийн үйл ажиллагаа сургалт бэлтгэлийн талаарх танилцуулга хийсний дараа бригадын генерал Г.Болор оролцогчдод хандан Эх оронч үзэл хүмүүжил, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар лекц уншиж залуусын сонирхсон асуултад хариулсан юм. Улаанбаатар хот болон 21 аймгаас хүрэлцэн ирсэн

эдгээр залууст 14 хонгийн хугацаанд хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгож, зөв хандлага, эх оронч үзэл санааг төлөвшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор төрөл бүрийн сургалтад хамруулахаас гадна үндэсний бүтээн байгуулалтад оролцуулж, ажлын байраар хангах, нийгмийн түншлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааны

хүрээнд дадлагажуулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн менторшип арга хэмжээнд хамруулах юм. Орлогчдын тухайд 8-34 насны, сүүлийн 3 сар ажил, хөдөлмөр эрхлээгүй, их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцадаггүй ажилтай, орлоготой болж ирээдүйгээ өөрчлөх хүсэлтэй залуусыг хамруулжээ.



## ЯПОН УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ ЦЭРГИЙН АТТАШЕ НАР МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙД АЙЛЧИЛЛАА



харилцаа тогтоосноос хойш стратегийн түншлэл, эдийн засаг, батлан хамгаалах, соёл урлагийн салбарт хоёр орны хамтын ажиллагаа өсөн нэмэгдэж байгаа билээ.

Үүний нэгэн жишээ болж 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсад ажиллах үүргээ амжилттай биелүүлээд нутаг буцаж байгаа цэргийн атташе ХИГАШИЯА Кейичи болон цаашид үүрэг гүйцэтгэх цэргийн атташе ИРИКИ Ёохей нар Монгол цэргийн музейд айлчиллаа.

Айлчлалын үеэр Монгол цэргийн музейн захирал хурандаа Д.Ганзориг цэргийн атташе нарыг хүлээн авч уулзсан бөгөөд уулзалтад Монгол Улс Япон улстай дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан хамтран зохион байгуулах гэрэл зургийн үзэсгэлэнгийн бэлтгэл ажлын талаар болон цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцэж санал солилцов.

Цэргийн атташе нар Монгол цэргийн музейг тайлбартайгаар үзэж сонирхон Монгол цэргийн дайчин уламжлалтай танилцан талархсанаа илэрхийлэн өндөр сэтгэгдэлтэй буцлаа.

Монгол цэргийн музей нь гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр сүүлийн жилүүдэд БНТУ, ОХУ, АНУ зэрэг орнуудын элчин сайдын яамд, түүний цэргийн атташе нартай хамтран Монгол Улсын түүх, цэргийн дайчин уламжлалыг харуулсан

музейн үзүүлэлэг дэглэлт хийх, сэдэвчилсэн үзэсгэлэнг зохион байгуулах, ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох чиглэлээр нэлээдгүй ажил, арга хэмжээг хэрэгжүүлсээр байгаа юм.

Монгол Улс Япон улстай 50 жилийн өмнө дипломат

## ЦДБЭЧ-ЫН УРЫН САНГИЙН ӨРӨӨГ ШИНЭЧЛЭН ЗАСВАРЛАН ТОХИЖУУЛЛАА



арга хэмжээ юм хэмээн морилон ирсэн ахмадууд, үе үеийн уран бүтээлчид, чуулгын удирдлага хамт олон талархлаа илэрхийлсэн юм. Ташрамд дуулгахад, чуулгын ахмадууд, тэдний үр хүүхдүүдтэй хамтран хийж хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд үргэлжилсээр байна.

ЦДБЭЧ-ын түүхт 90 жилийн ой тохиож байгаа бөгөөд тус чуулгаас тоглолт уран бүтээлийн болоод аж ахуй тохижилт үйлчилгээ, ахмадууд, түүний ар

Ард түмнээ "Тогдгор" хэмээн алдаршсан нэрт хөгжимчин, лимбэчин, ЦДБЭЧ-ын ахмад хөгжимчин МУГЖ Д.Галсантогтохын гэр бүл үр хүүхдүүд санаачлан зохион байгуулж, чуулгын урын сангийн өрөөг өөрсдийн төсөв хөрөнгөөр бүрэн засварлан тохижуулж хүлээлгэн өглөө.

Тус өрөөний нээлтийн арга хэмжээнд ЦДБЭЧ-ын удирдлага хамт олон, Ахмадын хорооны тэргүүлэгчид, алдартан гавьяатнууд тэргүүтэй эрхэм хүндтэй хүмүүс оролцлоо. Чуулгын уран бүтээлийн амин зүрх болсон урын санг хадгалалт хамгаалалтын стандартаар тохижуулан



өгч буй нь уран бүтээлүүд, соёлын биет болон биет бус өвүүдийг хойч үедээ өвлүүлэн үлдээхэд чухал нөлөө үзүүлэх

гэрийнхэн үр хүүхдүүдтэй нь хамтарсан олон арван ажлуудыг ийнхүү төлөвлөн хэрэгжүүлж байгаа билээ.

## ИХ ГОВИЙН ГАРНИЗОНЫХОН ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙГОО УГТАЖ ХИЙСЭН БҮТЭЭЛЧ АЖЛУУД ...

### Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн түүхт 90 жилийн ой энэ онд тохиож байгаа бөгөөд энэ хүрээнд "90 бүтээлч" ажлыг

тус ангийнхан санаачлан хэрэгжүүлж байна.

Тухайлбал, алба хаагчдынхаа ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд цөөнгүй ажил өрнүүлэхийн зэрэгцээ байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах, ангийн орчныг

эко хот болгохоор "Тэрбум" мод хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүний тод илэрхийлэл болж, Дорноговь аймгийн Зүүнбаян дахь "Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв"-ийг байгуулаад байна. Энэ төв байгуулагдсанаар жилд нэг сая тарьц, суулгацыг бэлтгэх

боломж бүрдэж байгаа юм.

Мөн түүхт ойн хүрээнд тус ангийнхан жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг ашиглалтад оруулж, гадна орчны зүлэгжүүлэлтийг гүйцэтгэж байгаа бөгөөд усан оргилуур болон 400


ширхэг хайлаас модны суулгац, 1000 ширхэг буйлс модны үрийг суулгаад байгаа юм. Түүнчлэн "Өөдлөх айл үүднээсээ" гэдэгчлэн шалган нэвтрүүлэх байрны гадна талбайн тохижуулалт, хаалгыг шинэчлэн засварлаад байна.

Ахлах дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ




Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ



ЦАХИМ ХУУДАС



\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

\* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шууданд: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)